

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-4

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 5-10

1.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.03.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ/	5-7
2.Байнгын хорооны тогтоолын төсөл /Нэр дэвших хүсэлтийн загвар батлах тухай/	7
3.Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан иргэдийн өргөдлийг хэлэлцэх /Хувь хүний орлогын албан татварын хэмжээг 1 хувь болгон бууруулах талаар/	7-8
4.Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан иргэдийн өргөдлийг хэлэлцэх /Улаанбаатар хотын тээврийн хэрэгслийн албан татварын хэмжээг нэмэгдүүлснийг хүчингүй болгох талаар/	8-10

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны
04 дүгээр сарын 09-ний өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 43 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Батбаяр, Х.Булгантуяа, Г.Ганбаатар, П.Мөнхтулга;
Чөлөөтэй: Б.Батцэцэг, Х.Болормаа, Ж.Ганбаатар, П.Ганзориг,
Г.Дамдинням, Б.Түвшин, Б.Чойжилсүрэн;
Эмнэлгийн чөлөөтэй: Д.Батлут.

Нэг.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.03.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Б.Батцэцэг, мөн газрын Хууль, эрх зүйн газрын ахлах референт Х.Сүрэнхорол, Салбарын бодлого, зохицуулалтын референт Б.Золбоо, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, мөн яамны Орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Монополын эсрэг газрын дарга Б.Билгүүн, Харилцаа холбооны зохицуулах хорооны Ажлын албаны дарга А.Лувсан-Очир, мөн хорооны Зохицуулалтын газрын дарга Т.Батболд, Цагдаагийн ерөнхий газрын Кибер гэмт хэрэгтэй тэмцэх газрын дарга С.Тайван, Хуулийн хэлтсийн дарга Б.Батзориг, Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав, Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн захирал С.Гантулга нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Нэг.Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Хоёр.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Гурав.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 50 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Нэр дэвших хүсэлтийн загвар батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн “Нэр дэвших хүсэлтийн загвар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ц.Даваасүрэн: “Нэр дэвших хүсэлтийн загвар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 4

Бүгд: 13

69.2 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Уг асуудлыг 15 цаг 52 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан иргэдийн өргөдлийг хэлэлцэх /Хувь хүний орлогын албан татварын хэмжээг 1 хувь болгон бууруулах талаар/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн Нийтийн өргөдлийг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ц.Даваасүрэн: Хувь хүний орлогын албан татварын хэмжээг 1 хувь болгон бууруулах талаар гаргасан иргэдийн өргөдлийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 95 дугаар зүйлийн 95.5.4-т заасны дагуу Татварын багц хуулийн хэрэгжилттэй танилцаж санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэгт шилжүүлэх саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 3
Бүгд: 13
76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Хувь хүний орлогын албан татварын хэмжээг 1 хувь болгон бууруулах талаар гаргасан иргэдийн өргөдлийг Татварын багц хуулийн хэрэгжилттэй танилцаж санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэгт шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 57 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан иргэдийн өргөдлийг хэлэлцэх /Улаанбаатар хотын тээврийн хэрэгслийн албан татварын хэмжээг нэмэгдүүлснийг хүчингүй болгох талаар/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн Нийтийн өргөдлийг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Мөн Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4.3-т заасны дагуу “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг Ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакирыг томилох нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

Ц.Даваасүрэн: Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 4
Бүгд: 13
69.2 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Б.Мөнхсоёл нарын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Ц.Даваасүрэн: “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 2
Бүгд: 13
84.6 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан, Ц.Даваасүрэн нарын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Уг асуудлыг 16 цаг 03 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 20 минут үргэлжилж, ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр 16 цаг 03 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ц.ДАВААСҮРЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
15 цаг 43 минут.

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Даваасүрэн: Эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амрыг айлтгая. Хуралдаанд оролцох 25 гишүүнээс 13 гишүүн ирж, 52 хувийн ирцтэй болсон учраас хуралдааныг эхлүүлэе. Өнөөдрийн хуралдаанд ирсэн гишүүдээ танилцуулна. Миний бие ирсэн байна, Алтанхуяг гишүүн ирсэн байна, Батбаяр гишүүн ирсэн байна, энэ чинь худлаа юм Батбаяр гишүүн алга байна. Алтанхуяг гишүүн, Батжаргал гишүүн, Мөнхсоёл гишүүн, Цогтбаатар гишүүн, Аубакир гишүүн, Баясгалан гишүүн, Заяабал гишүүн, Пүрэвдаваа гишүүн, Батболд гишүүн, Ганхуяг гишүүн, Мэндсайхан гишүүн, Тэмүүлэн гишүүн оролцож байна. Хуралдааны ирц 52 хувьтай байгаа учраас хуралдаанаа нээснийг мэдэгдье.

Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя. 4 асуудал байна. 1 дүгээрт Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Онцгой албан татварын хуульд өөрчлөлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг. Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлэх юм байна дүгнэлтээ. 2-т Нэр дэвших хүсэлтийн загвар батлах тухай гээд Аудитын даргын асуудал, Байнгын хорооны тогтоолын төсөл юм байна. 3.Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан иргэдийн өргөдлийг хэлэлцэх Хувь хүний орлогын албан татварын хэмжээг нэг хувь болгох тухай асуудал байгаа. 4-д Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар иргэдийн гомдлыг хэлэлцэх гээд энэ Улаанбаатар хотын авто тээврийн хэрэгслийн албан татварын нэмэгдлийг цуцлах тухай асуудлаар 4 дэх асуудал байна. Ийм 4 асуудал байна. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад саналтай гишүүн байна уу, алга уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оруулъя.

Нэг.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.03.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ/

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн болон Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, энэ чинь Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль уг төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, энийг засахгүй бол, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын

албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг эхэлье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 39.10-д заасны дагуу төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэх хуультай. Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 4 дүгээр, 4 зүйлтэй. Зүйл бүрээр хэлэлцье. 1.Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Тийм байна. Алга байна. Мөнхсоёл гишүүн байгаа юм уу? Мөнхсоёл гишүүн асуулт асууя. Андуурсан юм уу? Тэгвэл цуцалъя. Асуулт асуух гишүүн алга байна. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Тэгээд санал, Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна. Зарчмын зөрүүтэй саналтай гишүүн байна уу уг заалтаар? Алга байна. Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна. Уг зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна. Уг зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл 2 зүйлтэй. Мөн зүйл бүрээр хэлэлцэж эхэлье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. Уг зүйлээр зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна. Уг зүйлээр зарчмын зөрүүтэй санал гаргасан гишүүн байна уу? Алга байна. Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

3-д Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл 2 зүйлтэй. Төслийг зүйл бүрээр хэлэлцэж эхэлье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна. 1 дүгээр зүйлтэй холбогдуулаад зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна. Уг зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж дууслаа.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа. Хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Эдийн засгийн байнгын хороон дээр, Эдийн засгийн байнгын

хороонд хэн байгаа билээ? Ганхуяг гишүүн танилцуулъя. Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

15.50 цаг

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Нэр дэвших хүсэлтийн загвар батлах тухай/

2 дахь асуудалд оръё. Нэр дэвших хүсэлтийн загвар батлах тухай Төсвийн байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье. Тогтоолын төслийг та бүгдэд тараасан байгаа. Төрийн аудитын тухай хуулийн 28.1-д Улсын Их Хурлын даргын санал болгосноор Улсын Их Хурал Ерөнхий аудитыг 6 жилийн хугацаагаар томилно гэж, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30.6-д нэр дэвшигчийн дэлгэрэнгүй танилцуулгад томилогдсон тохиолдолд хийх ажил, нэр дэвшсэн үндэслэл, тухайн албан тушаалд тавих хуульд заасан нийтлэг болон тусгай шаардлагын талаарх мэдээллийг авах маягтын загварыг Байнгын хороо батална гэж ингэж заасан. Мөн Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 129.2-т эрх бүхий этгээд хуульд заасны дагуу нэр дэвшигчийг санал болгохдоо дээрх маягтын дагуу гаргаж Улсын Их Хуралд ирүүлнэ гэж заасны дагуу нэр дэвших хүсэлтийн загвар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төсөл загварын маягтыг боловсруулаад та бүхэнд тараасан байгаа.

Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна. Тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүн байна уу? Алга байна.

Нэр дэвшигчийн хүсэлтийн загвар болох тухай Төсвийн байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцож, 8 гишүүн дэмжиж, 61,5 хувиар дэмжигдсэн байна. Мөн Батжаргал гишүүнийг дэмжсэнээр протоколд тэмдэглүүлж байна. Ингээд 61,5 хувиар санал дэмжигдлээ. Байнгын хорооноос гаргах тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

15.52 цаг

Гурав.Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан иргэдийн өргөдлийг хэлэлцэх /Хувь хүний орлогын албан татварын хэмжээг 1 хувь болгон бууруулах талаар/

3 дахь асуудал. Хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж, 100 мянга гаруй иргэдээс гаргасан Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6.3-д заасан орлогод ноогдох албан татварын хэмжээг 1 хувь болгон бууруулах талаарх өргөдлийг хэлэлцэж эхэлье. Хуулийн дагуу хэрвээ яг ийм иргэдээс ирсэн өргөдөл гомдол 100 мянган хүний санал авчихвал тэгээд тэрийг 7 хоногийн дотор Их Хурлын дарга чиглэл өгсний дараа хэлэлцэж эхлэх ёстой юм байна лээ.

Нийтийн өргөдлийн мэдээллийг та бүхэнд танилцуулна. Улсын Их Хурлын хууль тогтоох, хянан шалгах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах зорилгоор нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар иргэдээс өргөдөл ирүүлэх d.parliament.mn цахим системд иргэн Р.Шинэгэрэлээс хувь орлогын татварын тухай хуулийн 6.3-д заасан орлогод ногдох албан татварын хэмжээг нэг

хувь болгон бууруулах асуудлаар хуулийн төсөл санаачлах тухай өргөдлийг Улсын Их Хурлын нийтийн өргөдөл гомдлын системд 2025 оны 3 дугаар сарын 29-ний өдөр байршуулсан байна. Тус нийтийн өргөдлийг 2025 оны 4 сарын 1-ний өдрийн байдлаар нийт 100187 хүн дэмжсэн байна.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39.4.1-д заасан шаардлага хангагдаж байна гэж үзэх бүрэн үндэслэлтэй болсон тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 95.3-д нийтийн өргөдлийг дэмжсэн иргэдийн санал энэ хуулийн 95.2-т заасан тоонд буюу 100 мянгаас дээш санал авсан тохиолдолд Улсын Их Хурлын дарга саналыг хэлэлцүүлж шийдвэрлэнэ гэж заасны дагуу Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн бөгөөд уг саналыг Байнгын хороо долоо хоногийн дотор хэлэлцэх дэгийн зохицуулалттай тул өнөөдрийн хуралдаа та хэлэлцэж байгаа юм. Тэгээд санал авах ажиллагааны үр дүнг та бүхэнд тараасан. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 95.5.4-д өргөдлийг хэлэлцээд, Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасны дагуу Улсын Их Хурлын дарга хууль тогтоомжийн төсөл, бодлогын баримт бичиг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах санал гаргах зохицуулалттай байгаа.

Тиймээс дээрх өргөдлийг Улсын Их Хурлын даргын захирамжаар батлагдсан Татварын багц хуулийн хэрэгжилттэй танилцаж санал, дүгнэлт гаргах, шаардлага бол хуулийн юу гэнэ, шаардлагатай бол хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулсан байгаа. Энэ ажлын хэсэгт шилжүүлэхээр ийм саналыг та бүхэнд оруулж байгаа.

Энэ иргэний ярьсан энэ саналыг Татварын ажлын хэсэгт шилжүүлье гэсэн энэ саналтай холбогдуулаад асуух асуулттай юм уу, саналтай гишүүн байна уу? Татварын ажлын хэсэгт шилжүүлээд явчихъя гэж байгаа юм. Авчих юм уу? Ингээд тэгвэл саналтай гишүүн алга байна. Тийм татварын ажлын хэсэгт шилжүүлж байгаа юм. Тийм шилжүүлье л гэж байгаа юм.

Тэгвэл саяын иргэн Р.Шинэгэрэлийн гаргасан Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6.1-д заасан орлогод ноогдох албан татварын хэмжээг нэг хувь болгох тухай энэ асуудлыг татварын ажлын хэсэгт шилжүүлье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Ажлын хэсэг байгуулагдсан байгаа байхгүй юу. Тэгээд нэгэнт байгуулагдсан Ажлын хэсэг рүү шилжүүлээд явчихъя гэж байгаа юм. Санал хураалтад 13 гишүүн оролцож, 9 гишүүний 69,2 хувиар дэмжигдсэн. Батжаргал гишүүн дэмжсэнээр протоколд тэмдэглэгдэж байна. Ингээд уг санал дэмжигдлээ. Татварын ажлын хэсэгт уг иргэний саналыг шилжүүллээ.

15.57 цаг

Дөрөв.Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан иргэдийн өргөдлийг хэлэлцэх /Улаанбаатар хотын тээврийн хэрэгслийн албан татварын хэмжээг нэмэгдүүлснийг хүчингүй болгох талаар/

Дараагийн асуудал. Хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж, 33 мянга гаруй иргэдээс гаргасан Улаанбаатар хотын тээврийн хэрэгслийн татварын нэмэгдлийг цуцлах талаарх нийтийн өргөдлийг хэлэлцэж эхэлье. Иргэн Э.Батбаяраас Улаанбаатар хотын тээврийн хэрэгслийн татварын нэмэгдлийг цуцлах асуудлаар Ажлын хэсэг байгуулах тухай өргөдлийг Улсын Их Хурлын

нийтийн өргөдөл гомдлын системд 2025 оны 3 сарын 20-ны өдөр байршуулсан. Тус нийтийн өргөдлийг 2025 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн байдлаар нийт 33042 иргэн дэмжсэн.

Тиймээс Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39.4.3-д заасан тодорхой асуудлаар Ажлын хэсэг байгуулах саналыг 33 мянга ба түүнээс дээш иргэн дэмжсэн гэсэн шаардлагыг хангасан тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 95.3-д заасны дагуу Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн бөгөөд хуулийн дагуу уг саналыг Байнгын хороо долоо хоногийн дотор хэлэлцэх дэгийн зохицуулалттай тул өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэхээр оруулж байна. Санал авах ажиллагааны үр дүнг та бүхэнд тараасан байгаа. Мөн дээрх өргөдлийн дагуу Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг бэлтгэн та бүхэнд тараасан. Дэгийн тухай хуулийн дагуу ажлын хэсэг байгуулагдах ёстой. Ингээд ажлын хэсгийн ахлагч болон ажлын хэсэгт орох гишүүд нэрээ өгье? Санал хэл, хэл. Ганхуяг гишүүн.

Х.Ганхуяг: Би энэ дээр ажлын хэсгийн ахлагчаар нь Аубакир гишүүн байвал яасан юм бэ гэж бодож байна. Яагаад гэхээр Улаанбаатар хотын гишүүд байх нь зохимжгүй. Энэ чинь нөгөө галтай асуудал, нөгөө сонгогдсон тойрогтой холбоотой асуудал байгаа болохоор 1 дүгээр асуудал.

2 дугаар асуудал иймэрхүү галтай асуудлын сэдвийг аваад гарчих туршлагатай гишүүн байвал зүгээр байх. Мөн Улаанбаатар хотод Монгол Ардын нам ялалт байгуулаад хотын захирагчийг томилоод явж байгаа болохоор МАН-аас нэр дэвшиж сонгогдсон гишүүнээр нь ахлуулбал зүгээр юм болов уу гэж бодож байна. Энэ дээр гишүүд маань дэмжээд өгчихвөл сайн юм болов уу гэж бодож байна. Баярлалаа.

Ц.Даваасүрэн: Заяабал, Аубакир 2-ын аль нь байвал дээр юм бэ? Ингээд горимын санал гаргасан учраас Ганхуяг гишүүний горимын саналаар санал хураалт явуулъя. Уг ажлын хэсгийг Аубакир гишүүнээр ахлуулъя гэж Ганхуяг гишүүний гаргасан горимын саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 13 гишүүн санал хураалт дээр 7 гишүүн дэмжсэн байна. Мөнхсоёл гишүүнийг дэмжсэнээр, Батжаргал гишүүнийг дэмжсэнээр протоколд авъя. Ингээд 53,8 хувиар уг санал дэмжигдсэн байна. Ажлын хэсгийн дарга тодорлоо.

Тэгэхээр ажлын хэсэгт орох гишүүд нэрээ өгнө үү, гишүүд ажлын хэсэгт орох гишүүд? Мөнхсоёл гишүүн, өөр, Баясгалан гишүүн, Заяабал гишүүн, өөр нэг гишүүн орчихмоор байна. Пүрэвдаваа гишүүн орох уу? Та иргэдийн Хуралд ажиллаж байсан хүн гол энийг сайн мэднэ шүү дээ. Пүрэвдаваа гишүүн. Ингээд саяын гишүүдийг биччихээрэй.

Би тогтоолын төслийг та бүхэнд уншиж танилцуулна. Байнга л иргэдийн Хурлаар яригдаж байдаг асуудал шүү дээ. Та сайн мэдэж байгаа. Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны тогтоол. 25 оны, дугаар, Ажлын хэсэг байгуулах тухай, Улаанбаатар хот. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4.3 дахь заалтыг үндэслэн Төсвийн байнгын хорооноос тогтоох нь:

1.Нийтийн өргөдлийн цахим системд иргэн Энхтөрийн Батбаярын 2025 оны 3 дугаар сарын 17-ны өдөр байршуулсан Улаанбаатар хотын авто тээврийн хэрэгслийн албан татварын нэмэгдлийг цуцлах талаар гаргасан саналыг 33042 иргэн дэмжсэн тул уг саналыг судлан үзэж санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Ажлын хэсгийн дарга Т.Аубакир Монгол Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн гишүүн Заяабал Монгол Улсын Их Хурлын гишүүн, Пүрэвдаваа Монгол Улсын Их Хурлын гишүүн, Мөнхсоёл Монгол Улсын Их Хурлын гишүүн, Баясгалан Монгол Улсын Их Хурлын гишүүн.

2.Ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх байгууллагын албан тушаалтныг тухай бүр татан оролцуулахыг ажлын хэсэгт зөвшөөрсүгэй. Төсвийн байнгын хороо. Ийм тогтоол байна. Тогтоолын төсөлтэй холбогдуулаад санал хэлэх, асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Тогтоолын төслийг баталъя гэдэг саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Би дэмжсэн шүү, энэ эсрэг явчихлаа. 13 гишүүн оролцож, 9 гишүүн дэмжиж 69,2 хувиар санал, Баясгалан гишүүн дэмжсэн байна, би дэмжсэн. Ингээд Ажлын хэсэг байгуулах тогтоол 69,2 хувиар дэмжигдлээ. Ажлын хэсгийн дарга Аубакир гишүүнд амжилт хүсье. Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

16.03 цаг

Төсвийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул Байнгын хорооны өнөөдрийн хуралдаан үүгээр өндөрлөж байна. Баярлалаа гишүүдээ.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

